



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Тохилог хараа" ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/004-НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: baasansurens@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	11
4. Аудитын тайлан	12
4.1. Ерөнхий зүйл.....	12
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	13
4.3.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.3.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
4.4. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.4.1 Завсрын аудитын талаар	14
4.5. Дараагийн аудитаар анхаарах асуудал:	15
5. Аудитын илрүүлэлт.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



“ТОХИЛОГ ХАРАА” ААТҮГ-ЫН ДАРГА
Н.ЦЭРЭНТОГТОХ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 001-2025/004/МА-СТА-0109/Г
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тохилог хараа” ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол “Тохилог хараа” ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- *Хог хаягдлын хураамжийн орлого 21,241.6 мянган төгрөгийг байгууллагын дансанд төвлөрүүлж, зарцуулсан,*
- *Ажиллагсдын цалин хөлсийг 1,371.8 мянган төгрөгийн зөрүүтэй тооцоолж, олгосон, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 5,315.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан,*
- *Худалдан авсан 46,824.1 мянган төгрөгийн бараа материалыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй,*
- *Санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, тайлант онд шинээр нэмэгдсэн газрыг бүртгэлд тусгаагүй.*

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хогийн цэгийг түрж булшлах зориулалтаар 185,000.0 мянган төгрөгийн “Гинжит трактор”, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 44,700.0 мянган төгрөгийн тракторыг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэл, тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

“Тохилог Хараа ААТҮГ”-ыг 46 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар баталсан бөгөөд 2024 онд нийт 80 хүн ажилд томилогдож, чөлөөлөгдсөн буюу хүний нөөцийн хөдлөл өөрчлөлт харьцангуй их байна.

Бусад асуудлын хэсэг

“Тохилог хараа” ААТҮГ-ын 2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлснийг Мандал сумын ИТХ-ын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 21 дугаар тогтоолоор “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1.	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	31,604,774.86	14,684,882.27
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	67,210.06	180,430.27
1.1.2	Дансны авлага	6,444,160.00	12,730,962
1.1.2.1	Дансны авлага /ТӨҮГ/	6,444,160	11,780,808
1.1.2.2	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/		950,154
1.1.3	Бараа материал	25,093,404.80	1,773,490
	Эргэлтийн хөрөнгийн дүн	31,604,774.86	14,684,882.28
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	19,656,619,819.81	17,380,293,026.47
1.2.1	Үндсэн хөрөнгө	18,637,035,622.14	482,723,164.8
1.2.2	Биет бус хөрөнгө	1,019,584,197.67	1,018,396,197.67
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,019,584,197.67	1,018,396,197.67
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,688,224,594.67	17,394,977,908.75
2.	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	33,598,042.38	21,479,303.49
2.1.1.1	Дансны өглөг	14,676,693	3,206,670.88
2.1.1.2	Цалингийн өглөг	735,231.78	1,487,403.09
2.1.1.3	Татварын өр	18,186,117.6	16,785,229.52
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	33,598,042.38	21,479,303.49
2.2	Өр төлбөрийн нийт дүн	33,598,042.38	21,479,303.49
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,014,238,197.67	1,014,238,197.67
2.3.2	Эздийн өмчийн бусад хэсэг	339,026,481.01	568,726,848.01
2.3.3	Хуримтлагдсан ашиг	18,299,814,026.73	15,788,986,079.7
2.3.4	Өмнөх үеийн үр дүн	20,755,150,125.22	18,300,003,155.73
2.3.5	Тайлант үеийн хуримтлагдсан ашиг	-2,455,336,098.47	-2,511,017,076.03
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,547,846.88	1,547,846.88
2.3.7	Эздийн өмчийн дүн	19,654,626,552.29	19,654,626,552.29
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	19,688,224,594.67	17,394,977,908.75

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1.	Борлуулалтын орлого (цэвэр)	922,213,111.00	1,247,274,251.4
1.1	Борлуулалтын өртөг	653,523,112.56	1,463,406,895.72
1.1.1	Нийт ашиг (алдагдал)	268,689,998.44	(216,132,644.32)
1.1.2	Түрээсийн орлого		
1.1.2.1	Хүүгийн орлого		
1.1.2.2	Ногдол ашгийн орлого		
1.1.2.3	Эрхийн шимтгэлийн орлого		2,367,821.66
1.1.2.4	Бусад орлого		
2.	Борлуулалт, маркетингийн зардал		
2.1	Ерөнхий ба удирдлагын зардал	231,041,169.13	125,239,511.54

2.1.1	Санхүүгийн зардал		
2.1.1.1	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,493,216,186.53	2,172,003,741.83
2.1.1.2	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
2.1.1.3	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-231,258.73	9,000
2.1.1.4	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
2.1.1.5	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
2.1.1.6	Бусад ашиг (алдагдал)		
2.2.1	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-2,455,336,098.49	-2,511,017,076.03
2.2.1.1	Орлогын татварын зардал		
2.2.1.2	Татварын дараах ашиг (алдагдал)	-2,455,336,098.49	-2,511,017,076.03
2.2.1.3	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
2.2.1.4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-2,455,336,098.49	-2,511,017,076.03
2.2.1.5	Бусад дэлгэрэнгүй орлого		
2.2.1.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
2.2.1.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-2,455,336,098.49	-2,511,017,076.03
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,070,199,311.00	1,417,071,917.06
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	243,297,911	290,123,317.06
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	147,986,200.00	287,697,268.4
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		50,106.66
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	826,901,400.00	1,126,948,600
1.1.6	Бусад мөнгөн орлого	95,311,711.00	2,375,942
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,061,307,489.12	1,415,228,796.84
1.2.1	Ажиллагчдад төлсөн	416,707,302.03	632,648,072.43
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	128,722,513.36	179,497,443.84
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	72,580,910.00	48,010,030
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	145,037,335.35	107,336,310.67
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	122,491,989.20	194,540,925.49
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	19,213,931.13	58,002,837.74
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,158,910.00	1,061,659
1.2.9	Бусад мөнгөн зарлага	155,394,598.05	194,131,517.67
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,891,821.88	1,843,120.22

2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,695,000.00	1,729,900
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,755,000.00	1,729,900
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,940,000.00	1,729,900
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	12,695,000.00	1,729,900
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,803,178.12	113,220.22
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,870,388.18	67,210.06
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	67,210.06	180,430.28

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	20,733,340,183.22	21,749,126,227.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			21,809,942	21,809,942
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	20,755,150,125.22	21,770,936,169.77
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	339,026,481.01			339,026,481.01
Тайлант үеийн үр дүн			-2,455,336,098.49	-2,455,336,098.49
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,353,264,678.68	1,547,846.88	18,299,814,026.73	19,654,626,552.29
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,353,264,678.68	1,547,846.88	18,299,814,026.73	19,654,626,552.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			189,129	189,129
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,353,264,678.68	1,547,846.88	18,300,003,155.73	19,654,815,681.29

Өмчид гарсан өөрчлөлт	229,700,000			229,700,000
Тайлант үеийн үр дүн			-2,511,017,076.03	-2,511,017,076.03
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,582,964,678.68	1,547,846.88	15,788,986,079.7	17,373,498,605.26

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	м/төг	1,409,589.1	1,417,071.90	-7,482.8	101%
	Хог үүсгэвэр, хог тээврийн төвлөрүүлэх орлого	м/төг	150,000.00	244,673.30	94,673.30	163%
	Татаас санхүүжилтийн орлого	м/төг	1,126,948.6	1,126,948.6	-	100%
	Бусад орлого	м/төг	44,362.80	2,375.90	-41,986.90	5%
	Туслах үйл ажиллагааны орлого	м/төг	88,277.70	43,074.10	-45,203.60	49%
2	Нийт зарлагын дүн	м/төг	1,408,899.61	3,928,088.98	-2,519,189.37	279%
	Цалингийн зардал	м/төг	789,057.34	632,648.10	-156,409.24	80%
	НДШ-ийн зардал	м/төг	107,157.13	179,497.40	72,340.27	168%
	Цэвэр усны зардал	м/төг	900	2016.9	1,116.90	224%
	Цахилгааны зардал	м/төг	105,660.00	88,300.50	-17,359.50	84%
	Дулааны зардал	м/төг	20,000.00	17,018.60	-2,981.40	85%
	Түлш, шатахууны зардал	м/төг	170,000.00	194,540.90	70,840.90	114%
	Урсгал засварын зардал	м/төг	26,700.00	4,025.80	-22,674.20	15%
	Бичиг хэргийн зардал	м/төг	2,959.04	1,487.90	-2,112.10	50%
	Албан томилолтын зардал	м/төг	1000	0	-1,000.00	0%
	Нормын хувцасны зардал	м/төг	20,800.00	9,675.00	-11,125.00	47%
	Сэлбэг хэрэгсэл	м/төг	120,000	10,041.40	10,041.40	8%
	Цэвэрлэгээ, ариутгалын зардал	м/төг	0	1,282.00	1,282.00	
	Шуудан холбооны зардал	м/төг	1,200.00	277.3	-922.7	23%
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	м/төг	2,900.00	31,213.40	28,313.40	0%
	Албан татвар, даатгалын зардал	м/төг	0	59,064.50	59,064.50	0%
	Нэг удаагийн тэтгэмж	м/төг	0	-	0	0%
	Бусад зардал /өглөг/	м/төг	39,800.00	189,233.50	173,233.54	0%
	Хөрөнгө оруулалт	м/төг	0	-	0	0%

3	Үндсэн хөрөнгийн элэгдэл	м/төг	0	2,507,756.70	2,507,756.70	0%
4	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	м/төг	0	9	9	0%
5	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	м/төг	766.1	-2,511,017.08	-2,510,250.98	0%
9	Орлогын албан татвар	м/төг	76.61	-2511017.076	2,510,940.47	0%
7	Татварын дараах ашиг, алдагдал	м/төг	689.48	-2511017.076	2,510,327.60	0%

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Тохилог хараа” ААТҮГ нь /цаашид Тохилог хараа ААТҮГ гэх/ “Мандал сумын иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцөлийг хангаж, өнгө төрхийг орчин үеийн хөгжлийн шинэ түвшинд хүргэх, ногоон байгууламжаа нэмэгдүүлж, байгальд ээлтэй иргэдтэй, хог хаягдлаа ангилдаг ногоон сум болгох” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Тохилог хараа” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто замын хог хаягдлыг цэвэрлэх, ачиж тээвэрлэх,
- Сумын төвийн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зөөж тээвэрлэх,
- Сумын төвийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа,
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт үйлчилгээ,
- Авто зам болон нийтийн эдэлбэр газрын гэрэлтүүлгийн ашиглалт, засвар үйлчилгээ,
- Гадаад, дотоод худалдаа эрхлэх,
- Авто тээвэр, бусад төрлийн машин механизмаар төлбөртэй үйлчлэх,
- Өөрийн эзэмшлийн хөрөнгө болон ажил үйлчилгээг бусдад түрээсээр ашиглуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Мандал сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор “Тохилог хараа” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулсан бөгөөд 2021 оноос улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга, тэмдгийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчилсөн байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах

талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай тус тус нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дугаар сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05, 12 дугаар сарын 12-нд өөрчлөлт орсон,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12-нд өөрчлөлт орсон гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Тохилог хараа” ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Тохилог хараа” ААТҮГ нь аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Тохилог хараа” ААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,293,246.7 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	67.2	180.5	113.3
Авлага	6,444.2	12,730.9	6,286.8
Бараа материал	25,093.4	1,773.5	(23,320.0)
Үндсэн хөрөнгө	19,656,619.8	17,380,293.0	(2,276,326.8)
Нийт хөрөнгийн дүн	19,688,224.6	17,394,977.9	(2,293,246.7)
Өр төлбөр	33,598.0	21,479.3	(12,118.7)
Эздийн өмч	19,654,626.6	17,373,498.6	(2,281,128.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	19,688,224.6	17,394,977.9	(2,293,246.7)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данс байна. Үүнд:

- Дансны авлага 12,730.9 мянган төгрөг болж нэмэгдсэн нь өөрийн үйлчилгээний орлогыг дутуу төвлөрүүлснээс шалтгаалсан байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 1,773.5 мянган төгрөг болж 23,320.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд гудамж талбайн гэрэлтүүлэг засварын ажил хийгдэж уг дансанд үлдэгдэлтэй байсан 214 ширхэг гэрлийн толгой зарлагдсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 19,656,619.8 мянган төгрөг болж 2,276,326,8 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өссөнөөс голлон шалтгаалсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 21,479.3 мянган төгрөг болж 12,118.7 мянган төгрөгөөр буурсан нь тооцоо нийлэн актаар баталгаажсан дансны өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Тохилог хараа” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Мандал сумын ИТХ-ын 2024 оны 133 дүгээр тогтоолоор “Тохилог хараа” ААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,409,589.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,408,899.6 мянган төгрөгөөр, цэвэр ашгийг 689.5 мянган төгрөгөөр тус тус тогтоож төлөвлөсөн /сумын ИТХ-ын 2024 оны 152 дугаар тогтоолоор татаас санхүүжилтийн орлого болон урсгал зардлыг тус бүр 150,256.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон/ байна.

- Нийт орлогын 80 хувийг татаас санхүүжилтын орлогоор, 10.6 хувийг хог тээврийн хураамжийн орлогоор, 9.4 хувийг мах бэлтгэлийн төвийн орлого болон түрээсийн орлогоор төвлөрүүлэхээр,
- Нийт зардлын 63.6 хувийг ажилчдын цалин, нийгмийн даатгалын зардалд, 8.9 хувийг байр ашиглалтын зардалд, 27.5 хувийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулахаар гэх мэт.

Гүйцэтгэлээр 1,249,642,1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,760,650.1 мянган төгрөгийн зардал гарган, 2,511,008.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын төлөвлөгөөний биелэлт 159,947.0 мянган төгрөгийн буюу 11.4 хувиар тасарсан байна. Хог тээврийн төвлөрүүлэх орлого 36,451.5 мянган төгрөгөөр буюу 24.3 хувиар давж биелсэн нь шинээр 42 аж ахуй нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулсантай холбоотой байна. Мах бэлтгэлийн төв нь 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 тоот тушаалаар үйл ажиллагааны үнэ тариф, А/07 тоот тушаалаар лабораторийн үйл ажиллагааны үнэ тарифыг тус тус шинэчлэн тогтоосон байна. Мах бэлтгэлийн төвийн орлого 11,501.9 мянган төгрөгөөр буюу 13 хувиар тасарсан нь тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүйгээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын төлөвлөгөөнд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал / 2024 оны хөрөнгийн элэгдлийн зардал - 2,507,756.7 мянган төгрөг/-ыг тооцож төлөвлөөгүйгээс зардал 3,928,088.98 мянган төгрөг болж 3.2 дахин хэтэрсэн харагдаж байна. Төлөвлөөгүй элэгдлийн зардлыг хасч тооцвол орлогын төлөвлөгөөг 11,432.7 мянган төгрөгөөр тасалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Тохилог хараа” ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн орлогын тайлагнал, үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Тохилог хараа” ААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны

орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 3,377,317.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **33,773.1** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

“Тохилог хараа” ААТҮГ нь тайлант хугацаанд шилэн дансанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 156 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Хугацаандаа мэдээлсэн, мэдээлэл оруулах ёстой 120 мэдээллээс 69 мэдээллийг “Оруулах мэдээлэл байхгүй”-г сонгосон буюу мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд:

- *Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр) – 1 дүгээр сард хугацаа хоцроосон бол*
- *Санхүүгийн тайлан - жил бүрийн 8 дугаар сар,*
- *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 1-12 дугаар сар,*
- *Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан – 7 дугаар сар,*
- *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг-1-12 дугаар сар,*
- *Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө – 1 дүгээр сар,*
- *Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт - 1-12 дугаар сар,*
- *Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт - 1-12 дугаар сарын мэдээллийг тус тус оруулах мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна.*

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж, мэдээллийг бүрэн байршуулж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.3.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Тохилог хараа” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Тог цахилгааны зардлыг 17,359.5 мянган төгрөгөөр,*
- *Халаалт, дулааны зардлыг 2,981,4 мянган төгрөгөөр,*
- *Бичиг хэргийн зардлыг 2,112,1 мянган төгрөгөөр,*
- *Албан томилотын зардлыг 1,000,0 мянган төгрөгөөр,*
- *Нормын хувцасны зардлыг 11,125,0 мянган төгрөгөөр,*
- *Урсгал засварын зардлыг 22,674.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэн,*
- *Хандив тусламжийн шинжтэй зардал гаргаагүй ажилласан байна.*

4.3.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шууд худалдан авах босго үнээс давсан түлш, шатахууны худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр Шунхлай петролиум, Сод монгол зэрэг компаниудтай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-ийн 1 дэх “Шууд худалдан авч болох болох төсөвт өртгийн дээд хязгаар:Бараа-20.0 сая төгрөг, ... ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн тус газрын худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.4.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 174 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд

аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй байна.

4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 9,885.1 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн 3 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 60.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	9,885.1	2	9,885.1	100.0
Зөвлөмж	3	-	2	-	66.7
Нийт дүн	5	9,885.1	4	9,885.1	80.0

Өмнөх аудитаар зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, ... эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10: “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтуудыг үндэслэн **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.5. Дараагийн аудитаар анхаарах асуудал:

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 74,752.8 мянган төгрөгийн зөрчил илэрч 4 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

1. Сумын төсөвт төвлөрүүлэх Хог хаягдлын хураамжийн орлого 21,241.6 мянган төгрөгийг байгууллагын дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.12: “Хог хаягдлын үйлчилгээний хураамж” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хог хаягдлын хураамжийн орлогыг сумын төсвийн Хог хаягдлын хураамжийн орлогын дансанд бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Ажилтнуудын цалин хөлс бодолт, цалин хөлсийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд тайлагнахтай холбоотой 6,687.0 мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Баталгаажсан цалингийн хүснэгтийн гарт олгох дүнгээс 5 ажилтны цалинг 1,371.8 мянган төгрөгөөр дутуу шилжүүлсэн,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 6 ажилтны 4,494.6 мянган төгрөгийн цалинг дутуу, 1 ажилтны 170.6 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан бол цалин бодогдоогүй 1 ажилтанд 650.0 мянган төгрөгийн цалин тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудын цалин хөлсийг тогтоосон хэмжээгээр бодож олгох, НДШ-ийн тайланд үнэн зөв тайлагнах, гарсан зөрчлийг 2025 оны эхний хагас жилийн тайланд залруулга хийх албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд 46,824.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4. Санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, тайлант онд шинээр нэмэгдсэн газрыг бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1: “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”: 14.4.2-д “бүх хөрөнгө, ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулж байх, нэмэгдсэн эзэмшил хөрөнгийг бүртгэлд тусгах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

1. Орлогын тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Борлуулалтын орлого, НӨАТ-ын тайлан, тооцоог тулган, хянаж, баталгаажуулахгүй байгаа нь НӨАТ-ын өр төлбөр үүсэх, татварын хяналт шалгалтаар хүү, алданги, торгууль ногдох эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: НӨАТ-ын тооцоог дахин хянаж, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

2.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа, ашиглах боломжгүй актлах нийт 47 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, дахин үнэлэх, актлах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй, байгууллагын эзэмшилд шинээр бүртгэгдсэн 1 газрыг бүртгэл тайланд орлого авч биет бус хөрөнгөд бүртгээгүй байна байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дэх “эд хөрөнгө засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, 31.3 дэх “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг актлаж устгах” 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”: 14.4.2: “бүх хөрөнгө, ...” гэсэн заалтуудыг болон УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-г зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, дахин ашиглах боломжгүй хөрөнгийг актлах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, байгууллагын эзэмшилд буй газрыг бүртгэл тайланд тусгах, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/						Зөвлөмж	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй
Дүн								

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хог хаягдлын хураамжийн орлогыг зарцуулсан	1	21,241.6			1	21,241.6						
Ажилтнуудын цалин хөлсийг буруу тооцоолсон, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд үнэн зөв тусгаагүй	1	6,687.0			1	6,687.0						
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан	1	46,824.1			1	46,824.1						
Хөрөнгийн тооллого хийгээгүй, газрыг бүртгэлд тусгаагүй	1				1							
Борлуулалтын орлого, НӨАТ-ын тайлан, тооцоог тулган, хянаж, баталгаажуулахгүй	1							1				
Хөрөнгийг дахин үнэлээгүй, актлах санал оруулаагүй	1							1				
Дүн	6	74,752.7			4	74,752.7		2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/					
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан шаардлага	Зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансанд 1 мэдээллийг хоцроож, 69 мэдээллийг мэдээлээгүй					1	1
Дүн					1	1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй					1	-
Дүн					1	-
Нийт дүн					2	1